

ШАЛГАЛТАД ОРОЛЦОГСДОД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

ШАЛГАЛТЫН ӨМНӨ

- Шалгалтын талаарх бүх мэдээллийг энэ цахим хуудаснаас уншина уу.
- Та шалгалтын асуулт ямаршүү байгааг болон хариултаа хаана бичихийг сайн хараарай. Даалгаврын эхлэл, хариултын загварыг ямагт анхааралтай уншаарай. Шалгалтад танаас юу хүсэн хүлээж байгааг нарийн мэдэх нь маш чухал юм.
- Та дараа нь Өөрийгөө турших шалгалт ыг хийж үзээрэй.
- Өөрийгөө турших шалгалтын дүнгээс хамааран шалгалтад орох эсвэл цааш сурах эсэхээ шийдээрэй.
- Та шалгалтад бэлдэхийн тулд интеграцын төвүүдийн чех хэлний дамжаанд хамрагдах, энэ цахим хуудас эсвэл Facebook хуудсан дээрх Zkouška z češtiny pro trvalý pobyt сургалтын материалыг ашиглаж болно.
- Та Онлайн өргөдөл бөглөх эсвэл сургууль дээр биечлэн ирж, бүртгүүлж болно. Шалгалт авах байгууллага (сургууль)-д сул орон тоо гармагц өргөдөл автоматаар үүсэж, танд баталгаажуулалт ирнэ. Бүртгүүлсэн дарааллын үндсэн дээр онлайн өргөдөл үүсдэг.
- Та шалгалт өгөх өдөр, цаг болон сургуулиа сонгоорой. Сургууль нь шалгалтын өдөр цагийг танилцуулах бөгөөд сул чөлөөтэй байх ёстой гэдгийг анхаарна уу!
- Шалгалт болохоос 14-өөс доошгүй хоногийн өмнө бүртгүүлж, нэр, овог, төрсөн он сар өдөр, иргэний харьяалал, паспортын дугаар, БНЧУ-д холбоо барих (гэрчилгээ илгээх) хаяг, утас, и-мэйл хаяг зэргийг бөглөх ёстой. Та заасан хугацаанаас оройтвол шалгалтад бүртгүүлэх боломжгүй!
- Шалгалт болохоос 8 хоногийн өмнө та биечлэн эсвэл бичгээр уучлал гуйж болно, эрүүл мэнд эсвэл хувийн хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд оройтож уучлал гуйвал хүлээж авахгүй.
- Шалгалт болохоос 8 хоногийн өмнө та хүчинтэй гадаад паспорттай сургууль дээр ирж Үнэмлэхээ (хэрэв танд байгаа бол) тушаах эсвэл шалгалтын төлбөрийг хийх ёстой.
- Шалгалтын үеэр өвдөх эсвэл хувийн онцгой асуудал гарсан бол та уучлал гуйж болно. Гэхдээ энэ тухайгаа сургуульд яаралтай мэдэгдэж, бичгээр үйлдсэн тодорхойлолтыг илгээх шаардлагатай.

ШАЛГАЛТЫН ӨДӨР

- Бүртгүүлэхдээ та гадаад паспортаа үзүүлнэ.
- Дараа нь ирцийн бүртгэлд гарын үсэг зурна.
- Шалгалт эхлэх цагаас 30 минутын өмнө ирсэн байх ёстой. Шалгалтад хоцорч ирвэл тухайн өдөр шалгалт өгөх боломжгүй; ийм учраас та өөр өдөр цагийг сургуультай тохирч, шалгалтын төлбөрийг хийх шаардлагатай.
- Бүртгүүлэхдээ бүртгэлийн дугаар бүхий карт авах бөгөөд уг дугаарын дагуу та бүх шалгалтаа өгнө.

- Шалгалтын танхимд орсны дараа шалгагч таны суух ширээг зааж өгнө. Та заасан ширээн дээр гадаад паспорт болон бүртгэлийн дугаар бүхий картыг тавих бөгөөд эдгээр нь бичгийн шалгалтын туршид ширээн дээр байх ёстой.
- Шалгалтын танхимд гар утас ямагт унтраалттай байх ёстой.
- Та цүнх, ном, тэмдэглэлийн дэвтэр, бичлэг хийх төхөөрөмж, гар утас, бүх цахим хэрэгслээ бусдад харагдахаар, гэхдээ таны ойр биш газар тавих хэрэгтэй.
- Бичгийн болон аман шалгалтыг нэг өдөр өгнө.
- Бичгийн шалгалтын явцад багш болон видео бичлэгийн заавраар ажиллана. Бичгийн шалгалт нийт 110 минут орчим үргэлжлэх ба эхний цагийн дараа завсарлага байна.
- Бичгийн шалгалтын хэсэг хоорондын завсарлага нь шалгалтын нэг хэсэг юм. Энэ завсарлагаар ч гар утсыг унтраасан байх ёстой.
- Бичгийн шалгалтын үеэр та танхимаас гарч болохгүй тул бичгийн шалгалт эхлэхээс өмнө эсвэл завсарлагаар бие засахыг зөвлөж байна.
- Та зөвхөн сургуулийн ажилтны зөвшөөрлөөр шалгалтын танхимд орж болно.
- Бичгийн шалгалтын явцад болон дараа нь та шалгалтын бүх хэсгүүдийг (өөрөөр хэлбэл хариултын хуудас, даалгавар) болон бүртгэлийн дугаар бүхий картыг хураалгана.
- Хэрэв та бичгийн шалгалтад тэнцвэл аман шалгалтад ямар дарааллаар орохыг хэлж өгнө. Хүндэтгэн үзэх шалтгаантай, жишээлбэл жирэмсэн эмэгтэйчүүд аман шалгалтыг түрүүлж өгнө.
- Сургуулийн ажилтнууд танд аман шалгалт хэзээ, хаана явагдахыг мэдэгдэнэ. Аман шалгалтад та товлосон цагийг баримтлан цагтаа ирэх ёстой.
- Аман шалгалт явагдаж буй танхимд орохоос өмнө та гадаад паспортаа үзүүлж, бүртгэлийн дугаар бүхий картыг дахин авна.

ШАЛГАЛТЫН ДАРАА

- Шалгалтын дүнг та шалгалт болсноос хойш 9 хоногийн дотор сургуулийн цахим хуудас эсвэл ажилтнаас шууд мэдэж болно.
- Шалгалтаа та амжилттай өгсөн бол гэрчилгээг тухайн сургууль дээр биечлэн авах эсвэл сургуулиас таны өргөдөлд заасан хаягаар 30 хоногийн дотор илгээх болно.
- Хэрэв та шалгалтад унавал шалгалтыг өөр хуваарьт өдрүүдэд дахин өгч болно. Та давтан шалгалт бүрийг төлөх ёстой.
- Та жилд дээд тал нь 3 удаа шалгалт өгч болно.
- Шалгалтын журмын үндсэн дээр шалгалтын баримт бичгийг биечлэн үзэж болохгүй, өөрөөр хэлбэл та шалгалтын даалгавар төдийгүй хариултын хуудсыг ч харах боломжгүй гэдгийг анхааруулж байна!